



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 01

Алтай

**Хөрөнгө шилжүүлэхийг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төгрөг сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгө тайлан балансад бүртгэлтэй цэцэрлэгийн хуучин барилгыг тус сумын ЗДТГ-ын хөрөнгөнд балансаас балансад Цагаанхайрхан болон Мааньт багийн төвийн зориулалтаар шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийг холбогдох байгууллагын баланс, хөрөнгийн бүртгэлээс хасаж шинээр бүртгэх хөдлөл өөрчлөлтийг зохих хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/, Орон нутгийн өмчийн албаны дарга /Л.Ганхуяг/- д даалгасугай.

ДАРГА



А.ДЭЛГЭРЖАРГАЛ